

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/227/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Мөрөн сум
2023 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр Утас: 99089114 цахим
хаяг: tegshdelgerb@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Давааням
Утас: 92113932 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn
Аудитор: Л.Мөнх-Оргил
Утас: 99039344 цахим хаяг: orgil.ikhuul@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ	3
1.1 Асуудлыг онцолсон хэсэг	3
1.2 Аудитын гол асуудал.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. АУДИТЫН ТАЙЛАН	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал.....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.1 Залруулсан алдаа.....	17
5.2 Төлбөрийн акт	17
5.3 Албан шаардлага	17
5.4 Зөвлөмж	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.08.24 № 01/107
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН
ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГА
Б.ДОЛЖИНСОРОГДОГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Орон нутгийн хөрөнгө оруулалт, ОНХС-аар хийгдсэн төсөл арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг ашиглагч байгууллагад шилжүүлэх хүртэл хугацаанд аймгийн Орон нутгийн өмчийн бараа материал дансны бусад эргэлтийн хөрөнгө хэсэгт тусгасан ба тайлант онд нийт 294.8 сая төгрөгийн хөрөнгийг ашиглагч байгууллагад шилжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэлийн хүрээнд үндсэн хөрөнгө, бараа материал, урсгал зардал болон Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянаж үзээд 10.8 сая төгрөгийн алдааг аудитын хугацаанд залруулж, 0.2 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 1 зөвлөмжийг хүргүүлж байна.

Бусад асуудлын хэсэг

Орон нутгийн өмчийн гарын дарга нь аймгийн Засаг даргатай 2022 онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, хэрэгжилтийг 84.6 хувьтай биелүүлж ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/төгрөгөөр/

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	455,466,816.00	162,427,123.92
33	АВЛАГА	2,991,000.00	100,611.92
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	100,611.92
335	Бусад авлага	2,991,000.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	2,991,000.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	452,475,816.00	162,326,512.00
354	Хангамжийн материал	452,475,816.00	162,326,512.00
35410	Бичиг хэргийн материал	240,626.00	270,950.00
35420	Аж ахуйн материал	2,132,290.00	6,221,562.00
35440	Түлш, шатах тослох материал	2,087,000.00	2,690,000.00
35470	Бусад хангамжийн материал	448,015,900.00	153,144,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	145,155,918.28	163,856,526.95
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	145,155,918.28	163,856,526.95
392	Биет хөрөнгө	98,000,918.28	120,259,526.95
39201	Барилга, байгууламж, орон сууц	00.00	49,133,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-272,961.11
39203	Авто-тээврийн хэрэгсэл	112,601,333.23	112,601,333.23
39204	Хуримтлагдсан элэгдэл	-61,481,685.27	-84,537,611.10
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	69,693,372.77	80,607,333.77
39206	Хуримтлагдсан элэгдэл	-31,729,906.46	-43,788,191.35
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	16,627,239.55	16,304,432.09
39208	Хуримтлагдсан элэгдэл	-7,709,435.54	-9,787,808.58
393	Биет бус хөрөнгө	47,155,000.00	43,597,000.00
39301	Програм хангамж	15,030,000.00	15,030,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-3,708,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	32,125,000.00	32,275,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	600,622,734.28	326,283,650.87
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	412,815,900.00	117,944,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	412,815,900.00	117,944,000.00
413	Өглөг	412,815,900.00	117,944,000.00
4136	Бусад өглөг	412,815,900.00	117,944,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	412,815,900.00	117,944,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	187,806,834.28	208,339,650.87
51	Засгийн газрын хувь оролцоо	187,806,834.28	208,339,650.87
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	10,875,000.00	11,025,000.00
51101	Өмч: - төрийн	10,875,000.00	11,025,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	176,931,834.28	197,314,650.87
51210	Өмнөх үеийн үр дүн	176,931,834.28	176,931,834.28
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	20,382,816.59
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	600,622,734.28	326,283,650.87

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	284,264,656.00	303,329,614.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	53,521,570.00	77,273,961.00
120	Нийтлэг татварын бус орлого	53,521,570.00	77,273,961.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	18,870,000.00	13,985,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	18,870,000.00	13,985,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	230,743,086.00	226,055,653.00

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,577,586.00	2,196,153.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,012,746.00	2,196,153.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,564,840.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	222,165,500.00	223,859,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	222,165,500.00	223,859,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	286,233,050.71	282,003,745.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	283,539,480.71	282,003,745.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	251,986,675.89	270,121,225.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	151,054,643.01	141,473,540.16
210101	Үндсэн цалин	140,298,468.01	106,460,644.35
210102	Нэмэгдэл	00.00	18,440,055.81
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,679,970.00	8,130,000.00
210104	Урамшуулал	5,076,205.00	8,442,840.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,861,522.17	17,566,960.01
210201	Тэтгэврийн даатгал	13,044,951.18	11,913,338.81
210202	Тэтгэмжийн даатгал	1,454,143.28	1,413,406.27
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,163,313.95	1,130,724.43
210204	Ажилгүйдлийн даатгал	290,828.10	282,679.92
210205	Эрүүл мэндийн даатгал	2,908,285.66	2,826,810.58
2104	Хангамж, бараа материалын зардал	25,849,132.00	22,438,453.00
210401	Бичиг хэрэг	6,549,912.00	3,817,376.00
210402	Тээвэр, шатахуун	6,387,420.00	5,989,050.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,612,900.00	6,453,202.00
210404	Ном, хэвлэл	5,135,600.00	4,984,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,014,300.00	1,194,225.00
210408	Бараа материал акталсны зардал	149,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,681,000.00	1,675,728.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,181,000.00	553,728.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,122,000.00
2107	Томилолт, зочны зардал	6,387,000.00	2,677,000.00
210702	Дотоод албан томилолт	6,387,000.00	2,677,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,320,658.00	7,797,244.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,364,840.00	6,783,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	297,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	50,000.00	39,750.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	243,194.00	243,194.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	286,000.00	282,500.00
210807	Газрын төлбөр	32,624.00	129,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	43,832,720.71	76,492,300.35
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	25,743,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,539,800.00	6,355,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	38,292,920.71	44,393,300.35
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,552,804.82	11,882,519.91
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,143,700.00	1,075,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,143,700.00	1,075,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	30,409,104.82	10,807,519.91
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	30,409,104.82	10,807,519.91
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,693,570.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,693,570.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-1,968,394.71	21,325,868.57
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	943,051.98

Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	943,051.98
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-943,051.98
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-1,968,394.71	20,382,816.59

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,875,000.00	173,148,421.76	184,023,421.76
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,875,000.00	173,148,421.76	184,023,421.76
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	631,381,040.23	631,381,040.23
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,875,000.00	176,931,834.28	187,806,834.28
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,875,000.00	176,931,834.28	187,806,834.28
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,875,000.00	176,931,834.28	187,806,834.28
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	150,000.00	00.00	150,000.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	20,382,816.59	20,382,816.59
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,025,000.00	197,314,650.87	208,339,650.87

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	249,613,086.00	240,040,653.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	18,870,000.00	13,985,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	18,870,000.00	13,985,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	18,870,000.00	13,985,000.00
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	18,870,000.00	13,985,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	230,743,086.00	226,055,653.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,577,586.00	2,196,153.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,012,746.00	2,196,153.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,564,840.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	222,165,500.00	223,859,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	222,165,500.00	223,859,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	246,883,086.00	240,040,653.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	246,883,086.00	240,040,653.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	215,330,281.18	228,158,133.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	151,054,643.01	141,473,540.16
210101	Үндсэн цалин	140,298,468.01	106,460,644.35
210102	Нэмэгдэл	00.00	18,440,055.81
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,679,970.00	8,130,000.00
210104	Урамшуулал	5,076,205.00	8,442,840.00

Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,861,522.17	17,667,571.93
210201	Тэтгэврийн даатгал	13,044,951.18	12,013,950.73
210202	Тэтгэмжийн даатгал	1,454,143.28	1,413,406.27
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,163,313.95	1,130,724.43
210204	Ажилгүйдлийн даатгал	290,828.10	282,679.92
210205	Эрүүл мэндийн даатгал	2,908,285.66	2,826,810.58
2104	Хангамж, бараа материалын зардал	23,256,524.00	22,918,177.00
210401	Бичиг хэрэг	3,613,304.00	3,694,100.00
210402	Тээвэр, шатахуун	6,880,420.00	6,592,050.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,612,900.00	6,453,202.00
210404	Ном, хэвлэл	5,135,600.00	4,984,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,014,300.00	1,194,225.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,950,000.00	3,372,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	450,000.00	850,000.00
210602	Тавилга	1,000,000.00	400,000.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	2,122,000.00
2107	Томилолт, зочны зардал	6,387,000.00	2,677,000.00
210702	Дотоод албан томилолт	6,387,000.00	2,677,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,320,658.00	7,797,244.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,364,840.00	6,783,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	297,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	50,000.00	39,750.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	243,194.00	243,194.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	286,000.00	282,500.00
210807	Газрын төлбөр	32,624.00	129,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,499,934.00	32,252,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	25,743,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,499,934.00	6,509,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,552,804.82	11,882,519.91
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,143,700.00	1,075,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,143,700.00	1,075,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	30,409,104.82	10,807,519.91
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	30,409,104.82	10,807,519.91
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	2,730,000.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	2,730,000.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,730,000.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,730,000.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,730,000.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-2,730,000.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү хувь

Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	233,859,500.00	227,036,980.09	6,822,519.91	97.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	233,859,500.00	227,036,980.09	6,822,519.91	97.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	232,784,500.00	225,961,980.09	6,822,519.91	97.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	145,870,100.00	139,521,404.16	6,348,695.84	95.6
210101	Үндсэн цалин	132,950,100.00	104,718,508.35	28,231,591.65	78.8
210102	Нэмэгдэл	00.00	18,440,055.81	18,440,055.81	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,920,000.00	7,920,000.00	0.00	100.0
210104	Урамшуулал	5,000,000.00	8,442,840.00	-3,442,840.00	168.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,702,500.00	17,423,554.93	278,945.07	98.4
210201	Тэтгэврийн даатгал	11,728,300.00	11,848,017.73	-119,717.73	101.0
210202	Тэтгэмжийн даатгал	1,573,300.00	1,393,884.27	179,415.73	88.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,167,500.00	1,115,107.43	52,392.57	95.5
210204	Ажилгүйдлийн даатгал	294,000.00	278,776.92	15,223.08	94.8
210205	Эрүүл мэндийн даатгал	2,939,400.00	2,787,768.58	151,631.42	94.8
2104	Хангамж, бараа материалын зардал	22,918,900.00	22,918,177.00	723.00	100.0
210401	Бичиг хэрэг	4,046,700.00	3,694,100.00	352,600.00	91.3
210402	Тээвэр, шатахуун	6,467,600.00	6,592,050.00	-124,450.00	101.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,131,500.00	6,453,202.00	-321,702.00	105.2
210404	Ном, хэвлэл	5,048,000.00	4,984,600.00	63,400.00	98.7
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,225,100.00	1,194,225.00	30,875.00	97.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,372,000.00	3,372,000.00	0.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	850,000.00	850,000.00	0.00	100.0
210602	Тавилга	400,000.00	400,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	2,122,000.00	2,122,000.00	0.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	2,746,000.00	2,677,000.00	69,000.00	97.5
210702	Дотоод албан томилолт	2,746,000.00	2,677,000.00	69,000.00	97.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,828,400.00	7,797,244.00	31,156.00	99.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,783,300.00	6,783,300.00	0.00	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	297,400.00	297,400.00	0.00	100.0

210803	Даатгалын үйлчилгээ	45,000.00	39,750.00	5,250.00	88.3
210804	Тээврийн хэрэгслийн татвар	243,200.00	243,194.00	6.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	47,400.00	22,000.00	25,400.00	46.4
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	282,500.00	282,500.00	0.00	100.0
210807	Газрын төлбөр	129,600.00	129,100.00	500.00	99.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32346600.00	32252600.00	94,000.00	99.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	25,837,500.00	25,743,500.00	94,000.00	99.6
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,509,100.00	6,509,100.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1075000.00	1075000.00	0.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,075,000.00	1,075,000.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,075,000.00	1,075,000.00	0.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	233,859,500.00	227,036,980.09	6,822,519.91	97.1
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	198,022,000.00	213,051,980.09	15,029,980.09	107.6
132001	Орон нутгийн төсвөөс	198,022,000.00	213,051,980.09	15,029,980.09	107.6
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	35,837,500.00	13,985,000.00	21,852,500.00	39.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,000,000.00	13,985,000.00	-3,985,000.00	139.9
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	25,837,500.00	00.00	25,837,500.00	0.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	10.00	10.00	0.00	100
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100
620002	Гүйцэтгэх ажилтан	07.00	07.00	0.00	100
620003	Үйлчлэх ажилтан	02.00	02.00	0.00	100

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,196,153.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,196,153.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,196,153.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,952,136.00
210101	Үндсэн цалин	1,742,136.00

210103	Унаа хоолны хөнгөлөлт	210,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	244,017.00
210201	Тэтгэврийн даатгал	165,933.00
210202	Тэтгэмжийн даатгал	19,522.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,617.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,903.00
210205	Эрүүл мэндийн даатгал	39,042.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2196153.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,196,153.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,196,153.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. Аудитын тайлан

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газар нь хууль журамд заасан чиг үүргийг орон нутагт хэрэгжүүлэх, мэдээллийн сан үүсгэж ажиллах зорилготой байна.

Байгууллагын үндсэн чиг үүргийг дараах байдалтай тодорхойлсон байна. Үүнд:

1. Орон нутгийн өмчийн талаар баримтлах аймгийн бодлогын баримт бичиг, хөтөлбөр чиглэлийг боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангах, үр дүнг тайлагнах, өмчийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, үр дүнг тайлагнах
2. Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийг нэгдсэн удирдлагаар хангах, түүний үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийж, шийдвэрийн төсөл, дүгнэлтийг хувьцаа эзэмшигчдийн хуралд хэлэлцүүлэх, орон нутгийн өмчийн төлөөлөл, компанийн засаглалын шилдэг загварыг боловсруулж, хэрэгжүүлэх
3. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн төсвийн зарцуулалтын гүйцэтгэлд хяналт тавих, төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн бараа, ажил, үйлчилгээг хүлээн авах, данс бүртгэлд тусгах, гүйцэтгэлийн чанарын баталгааны барьцаа хөрөнгө чөлөөлөх зэрэг арга хэмжээг зохион байгуулж, гүйцэтгэл үр дүнг тайлагнах
4. Орон нутгийн өмчийн төлөөлөгчийг томилох, чөлөөлөх, урамшуулах, хариуцлага тооцох журам, хуулийн этгээдийн дүрэм, бизнес төлөвлөгөө, зохион байгуулалтын бүтэц, бодлогын баримт бичиг, цалин хөлсний норм, норматив, гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний төслийг боловсруулж батлуулах, биелэлтэд хяналт тавих, тайлагнах
5. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглалыг хэрэгжүүлэх зорилтот түвшинг оновчтой төлөвлөж, биелэлтийг хянаж, дүгнэлт, шийдвэрийн төслийг төлөөлөн удирдах зөвлөл, хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулан шийдвэрлүүлэх
6. Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийн дүрмийн хэрэгжилт, үйлдвэрлэлийн техник, технологи, санхүү, эдийн засаг, хүний нөөцийн

- төлөв байдал, чиг хандлагад судалгаа шинжилгээ хийх, үнэлэлт дүгнэлт өгөх замаар шаардлагатай арга хэмжээ авах, орон нутгийн өмчит хувьцаат компаниудаас нэмэлт хувьцаа гаргах, арилжих саналыг аймгийн ИТХ-ын хуралдаанд хэлэлцүүлэх.
7. Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийг хувьчлах төслийг боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулах, хэрэгжилтийг хангах, хувьчлах орон нутгийн өмчийн жагсаалтыг гаргаж холбогдох байгууллагад хянуулж аймгийн ИТХ-ын хуралдаанд хэлэлцүүлэх
 8. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эзэмшилд байгаа барилга байгууламж, эд хөрөнгийн ашиглалт, захиран зарцуулалтад өмч эзэмшлийн гэрээ байгуулан хяналт тавих, гэрээ дүгнэх
 9. Орон нутгийн өмчийн бүртгэл, тооллого явуулах, өмч хөрөнгийн бүрэн бүтэн байдал, орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих
 10. Орон нутгийн өмчийн нэгдсэн бүртгэлийг хөтөлж, мэдээллийн санг бүрдүүлэх, баяжуулах, бүртгэлээр хяналт тавих
 11. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг худалдах, шилжүүлэх, актлах, олж авах саналыг хянаж шийдвэрлүүлэх
 12. Хөрөнгийн хөдлөлийг бүртгэлд тусгуулах, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайланг хүлээн авч хяналт, үнэлгээ хийх нэгтгэх
 13. Орон нутгийн өмчийн барилга, байгууламж, эд хөрөнгийг түрээслүүлэх, гэрээг батлах, түрээсийн орлогыг орон нутгийн төсөв, хуулийн этгээдийн дансанд оруулах ажлыг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулах, үр дүнг тайлагнах
 14. Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийн нягтлан бодох бүртгэл, өмчийн бүртгэл, хяналт хариуцсан мэргэжилтнүүдэд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх
 15. Орон өмчийн захиран зарцуулалт, хадгалалт, хамгаалалт, хяналт мониторингтой холбоотой шийдвэр гаргахад оролцогчдоос ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг гаргуулах, орон нутгийн өмчийн бодлогын баримт бичиг боловсруулах шатанд эрх ашиг нь хөндөгдөж болзошгүй этгээдүүдийг оролцуулсан нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах зэрэг үйл ажиллагааг зохион байгуулж, тайлагнах
 16. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ нийлүүлэх гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, гэрээ дүгнэх, бараа, ажил, үйлчилгээ хүлээн авах төслийн баг, улсын комиссын бүрэлдэхүүнд ажиллах

3.2 Байгууллагын гадаад дотоод орчин

Байгууллагын үндсэн мэдээлэл, түүний гадаад орчин болон дотоод үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэлийн үйл явцыг судалж, ойлгосноор эрсдэлтэй асуудлыг тодорхойлж баримтжуулав.

Тайлант онд дараах хуулиуд шинэчлэгдэн баталж, мөрдсөн байна. Үүнд:

1. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 1-ээс хэрэгжиж эхэлсэн.
2. Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн "Төрийн хэмнэлтийн тухай" хууль хэрэгжиж эхэлсэн.
3. Төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор тогтоосон ба 2022 оны 192 дугаар тогтоолоор эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг өөрчлөн тогтоосон байна.

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-д заасны дагуу дотоод хяналт шалгалт хийх нэгж, ажилтныг томилон ажиллуулаагүй байна. Харин Орон нутгийн өмчийн газрын даргын 2020 оны Б/06 тоот

тушаалаар худалдан авах ажиллагааны мэргэжилтэн Д.Төмөрт байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, хяналт шинжилгээ үнэлгээ хийх чиг үүргийг хариуцуулж, ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг 20 хувиар олгох шийдвэр гаргаж, цалинг нэмэгдүүлсэн байна. Тайлант хугацаанд дотоод хяналт хариуцсан ажилтан 2022 онд дотоод хяналт хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж батлуулаагүй, дотоод хяналтыг хангалттай хэрэгжүүлээгүй байна.

Тус байгууллага нь аймгийн Засаг даргын 2019 оны А/375 дугаар захирамжаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэн тул тус бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулах шаардлага тулгараад байна. Гэхдээ санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл, төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна гэж үзлээ.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Орон нутгийн өмчийн газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 274.3 сая төгрөгөөр буюу 45.6 хувиар буурсан байна.

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Дансны авлага	2.9	0.1	2.8
Бараа материал	452.5	162.3	290.2
Үндсэн хөрөнгө	145.2	163.8	(18.7)
Биет бус хөрөнгө			
Нийт хөрөнгө	600.6	326.3	274.3
Дансны өглөг	412.8	117.9	294.9
-терийн	10.9	11.0	0
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл			
Хуримтлагдсан үр дүн	100.9	142.1	(41.2)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	600.6	326.3	274.3

Нийгмийн даатгалын хэлтсээс 0.1 сая төгрөгийн авлагатай байгаа ба харилцагч байгууллагатай тооцоо нийлж баталгаажуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 294.9 сая төгрөгөөр буурсан нь аж ахуйн материал болон бусад хангамжийн материал дээр байсан ОНӨГ-ын даргын 2022 оны А/46 дугаар тушаалаар Шинэ хөдөө төслийн хүрээнд хэрэгжсэн 175 толгой малыг “Хөдөөгийн шийдэл” ХХК-д шилжүүлсэн байна. Мөн 2.4 сая төгрөгийн хөрөнгийн шинж чанар бүхий зүйлсийг аймгийн ИТХ-ын даргын 2022 оны А/92 дугаар захирамж, ОНӨГ-ын даргын 2022 оны А/91 дүгээр тушаалаар, урьд оны авлага болох 1.0 сая төгрөгийн аж ахуйн бараа материалыг тус тус орлогод авсан байна. Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4.2 сая

төгрөгөөр буурсан нь аймгийн ИТХ-ын даргын 2022 оны А/92 дугаар захирамжийн дагуу 6 нэр төрөл бүхий хөрөнгө акталсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 18.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд:

- ТӨБЗГ-ын даргын 2022 оны Б/106 дугаар тушаалын дагуу 2.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлэн авсан.
- ОНӨГ-ын даргын 2022 оны А/88 дугаар тушаалын дагуу 1.3 сая төгрөгийн, 2022 оны А/91 дүгээр тушаалаар 49.1 сая төгрөгийн, 2022 оны А/95 дугаар тушаалын дагуу 2.2 сая төгрөгийн, 2022 оны А/112 дугаар тушаалын дагуу 2.7 сая төгрөгийн, урд оны авлага болох 1.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгүүдийг орлогод авсан байна.

Хуримтлагдсан үр дүн 41.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Дансны өглөг дансны үлдэгдэл 294.9 сая төгрөгөөр буурсан нь аймгийн ОНӨГ-ын даргын 2022 оны А/46 дугаар тушаалын дагуу Шинэ хөдөө төслийн хүрээнд хэрэгжсэн 175 толгой малыг “Хөдөөгийн шийдэл” ХХК-д шилжүүлсэнтэй холбоотой байна.

Төрийн өмч 0.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь 2022 оны орон нутгийн өмчийн улсын нэгдсэн үзлэг тооллогоор кадастарын зөрүү болох 0.1 мянган төгрөгийн газар бүртгэсэнтэй холбоотой байна.

Хуримтлагдсан элэгдэл данс 41.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь 2022 онд үндсэн хөрөнгийн элэгдэлийг 44.4 сая төгрөгөөр байгуулсан ба үлдэх өртөгтэй хөрөнгө актласантай холбоотойгоор 3.2 сая төгрөгөөр дансны хасалт хийсэнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 291.2 сая төгрөгөөр төлөвлөж санал хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн саналаас 70.3 сая төгрөгөөр бууруулж орон нутгийн төсвөөс 220.9 сая төгрөгөөр баталсан байна. Аймгийн ИТХ-ын 2022 оны 6 дугаар сарын 22-ны 10 дугаар тогтоолоор тус байгууллагын төсвийг 2.6 сая төгрөгөөр хасах, 10.5 сая төгрөгөөр нэмэх тодотгол хийж 233.8 сая төгрөг болгож тодотгон баталсан байна. Тус газрын 2022 оны төсвийг 2021 оны төлөвлөгөө гүйцэтгэлтэй харьцуулбал дараах байдалтай байна. **Үүнд:**

Үзүүлэлт	2022 оны батлагдсан төсөв	2021 оны		Төлөвлөгөөтэй харьцуулсан дүн	/сая төгрөгөөр/ Гүйцэтгэлтэй харьцуулсан дүн
		төлөвлөгөө	гүйцэтгэл		
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	233.8	232.1	210.6	1.7	23.2

Хүснэгтээс харахад: 2022 оны төсвийг батлахдаа 2021 оны төлөвлөгөөнөөс 1.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлээс 23.2 сая төгрөгөөр нэмж баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 зориулалт арга хэмжээг санхүүжүүлэхээр 233.8 сая төгрөгийн төсөв баталсан 95.8 хувь нь орон нутгийн төсвөөс, 4.2 хувь буюу 10.0 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 237.8 сая төгрөгийн эх үүсвэрийг хүлээн авч, 227.0 сая төгрөгийг урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулж, 10.8 сая төгрөгийг төсөвт

буцаан төвлөрүүлсэн байна. Харин үндсэн үйл ажиллагааны орлогыг 3.9 сая төгрөгийг давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт 1. Хөтөлбөр, арга хэмжээний зардал

/сая төгрөгөөр/

Хөтөлбөр, арга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
70426	Төрийн өмчийн хэрэгжүүлэх	233.8	227.0	6.8	97.1
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	205.2	198.4	6.7	96.7
80205	Мэдээлэл сурталчилгааны зардал	0.8	0.8	0	100
81103	Эрсдэлийн сангийн нөөц хөрөнгө	1.0	1.0	0	100
80802	Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	1.0	1.0	0	100
81545	Төрийн болон орон нутгийн өмчийн үзлэг тооллого	25.8	25.7	0.1	99.6

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 227.0 сая төгрөг буюу 97.1 хувьтай байна. Тайлант оны төсвийн үлдэгдэл 10.8 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн ба энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7¹ дахь заалттай нийцэж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан нэмэлт орлого 2.2 сая төгрөгийг нэмэлт дансанд орлогоор хүлээн зөвшөөрсөн байна.

Үүнээс цалин урамшуулалд 1.9 сая төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 0.3 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газрын байгууллагын дотоод хяналтыг сайжруулах талаар 1 зөвлөмж, төсөв зориулалт бусаар зарцуулсан 0.2 сая төгрөгийн төлбөрийн акт, төвлөрүүлэг шилжүүлэг данстай холбоотой 10.8 сая төгрөгийн залруулга хийсэн болно.

¹ Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын аудитор Л.Мөнх-Оргил гүйцэтгэж, хяналтыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 1/50 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 271.7 сая төгрөгөөс 2 хувиар буюу 5.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 4.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд дараах зөрчил илэрсэн. Үүнд:

1. Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс худалдан авах зардлаас 0.2 сая төгрөгөөр байгууллагын үндсэн үйл ажиллагаанд шаардлагагүй хоол хүнс, бэлэг дурсгалын зүйл бэлтгэсэн зөрчил илэрсэн болно. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.7² дах заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5³ дах заалтыг тус тус зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэлээ.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянаж үзэхэд мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж ажилласан бөгөөд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд:

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн бусад хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж үзлээ.

² Байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах.

³ Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Хөвсгөл аймгийн орон нутгийн өмчийн газрын 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар 158.0 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмжийг өгч, 5.5 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн актыг тогтоосон байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	158.0	2	158.0	100
Акт	2	5.5	2	5.5	100
Албан шаардлага	0	0.0	0	0.0	
Нийт дүн	4	163.5	4	163.5	100

Орон нутгийн өмчийн газрын улсын бүртгэлийн гэрчилгээ нь дэх дүрмийн сангийн хэмжээ, санхүүгийн тайлан дахь төрийн болон орон нутгийн эзэмшлийн өмчийн дүнгийн зөрүү, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар хүргүүлсэн 2 зөвлөмж, албан хаагчдад үндэслэлгүй баримт бүрдүүлэн олгосон албан томилолт төлүүлэх, цалингийн зардлаас байгууллагын даргад өөрийнх нь тушаалаар олгосон урамшууллыг буцаан төлүүлэх 2 төлбөрийн актыг бүрэн биелүүлж ажилласан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал:

Дараагийн аудитаар давтан шалгах онцгой асуудал байхгүй байна.

5. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 11.0 сая төгрөгийн 1 алдаа, 1 зөрчил илэрсэн. Аудитын явцад 10.8 сая төгрөгийн бүртгэл тайлагналтай холбоотой 1 алдааг залруулж, төсөв зориулалт бусаар зарцуулсан 0.2 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоосон болно.

5.1 Залруулсан алдаа

Орон нутгийн өмчийн газрын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 10.8 сая төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлэгтэй холбоотой залруулгыг аудитын хугацаанд хийсэн болно.

1.2 Төлбөрийн акт

Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс худалдан авах зардлаас 0.2 сая төгрөгөөр байгууллагын үндсэн үйл ажиллагаанд шаардлагагүй хоол хүнс, бэлэг дурсгалын зүйл бэлтгэсэн зөрчил илэрсэн болно. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.7 дах заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дах заалтыг тус тус зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.3 Албан шаардлага

Орон нутгийн өмчийн газрын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага хүргүүлээгүй болно.

5.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Байгууллагын дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн нь байгууллагын дотоод хяналт хийх ажлын төлөвлөгөөг батлуулж, төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж илэрсэн алдаа зөрчилд зөвлөмжийг өгч ажиллаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6 дахь заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Дотоод хяналтын ажлын төлөвлөгөөг батлуулахдаа Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 4.1-д заасан чиглэлийг баримтлах, алдаа зөрчлийг арилгах хугацаатай зөвлөмжийг өгч, хэрэгжилтийг тооцож ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Аудитаар илэрсэн алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үлдэгдэл төвлөрүүлээгүй.	1	10.8	1	10.8			1	10.8				
Дүн	1	10.8	1	10.8			1	10.8				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төсөв зориулалт бусаар зарцуулсан	1	0.2	1	0.2								
Байгууллагын дотоод хяналт шалгалтын төлөвлөгөө батлуулан, хяналт шалгалт хийж хэрэгжүүлээгүй.	1	-					1	-				
Дүн	2	0.2	1	0.2			1	-				

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:
 ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
 АНХАН ШАТАНД ХЯНАСАН:
 АУДИТЫН МЕНЕЖЕР
 АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

Б.ДАВААНЯМ ОГНОО:

АУДИТОР

Л.МӨНХ-ОРГИЛ